



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 08 сарын 29 өдөр

Дугаар А/483

Хэрлэн сум

Гоц халдварт хонины цэцэг өвчнөөс
урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын
ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.9 дэх хэсэг, Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2025 оны А/264 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээний бүх хонин сүргийг цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 29 хоногт багтаан шуурхай зохион байгуулсугай.

2. Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын чанар, явц, гүйцэтгэлд хөндлөнгийн хяналт тавьж ажиллах аймгийн Онцгой комиссын гишүүдийн хуваарийг хавсралтаар баталсугай.

3. Малчдад урьдчилан мэдэгдэж тарилгын хашаа, хоолойг бэлтгүүлэх, дархлаажуулалтад ажиллах хүн хүч, машин техник, шатах тослох материалын бэлэн байдлыг хангуулан, багийн Засаг дарга нарыг үүрэгжүүлж ажиллахыг сумын Засаг дарга нарт даалгасугай.

4. Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад графикт хугацаанд мал сүргээ бүрэн хамруулаагүй, хамруулахаас зайлсхийсэн малчид, мал бүхий иргэд, заавар, журмыг баримтлаагүйн улмаас малын өвчин гарах нөхцөлийг бүрдүүлсэн албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг Мал эмнэлгийн газрын хяналтын улсын байцаагч нарт үүрэг болгосугай.

5. Дархлаажуулалтад шаардлагатай вакцин, мэргэжил арга зүйн заавар зөвлөмжөөр хангах, гүйцэтгэлийг хянаж шалгах, үр дүнг танилцуулахыг Мал эмнэлгийн газрын дарга (Н.Анхбаяр)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Өнөрцолмон)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.АЮУРБУНЬ



08 Аймгийн Засаг даргын 2025 оны
дугаар сарын 29-ний өдрийн
А/Н/85 дугаар захирамжийн хавсралт

Малын гоц халдварт шүлхий өвчний дархлаажуулалтын ажилд хяналт
тавьж, хариуцан ажиллах онцгой комиссын гишүүдийн хуваарь

Д/Д	Сумдын нэр	Онцгой комиссын гишүүдийн нэрс	Албан тушаал
1	Галшар	Б.Амгаланбат	Байгаль орчны газрын дарга
2	Баянхутаг	Б.Өнөрцолмон	Аймгийн Засаг даргын орлогч
3	Баянмөнх	О.Баярлхагва	Тагнуулын хэлтсийн дарга
4	Дархан	Б.Золбоо	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
5	Дэлгэрхаан	А.Жаргалсайхан	Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
6	Жаргалтхаан	Ж.Эрдэнэбат	Онцгой байдлын газрын дарга
7	Цэнхэрмандал	Ү.Энх-Ариунаа	Улаан загалмайн хорооны дарга
8	Өмнөдэлгэр	Д.Батхүү	Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
9	Батширээт	Л.Цэнддорж	Цэргийн штабын дарга
10	Биндэр	Л.Дашнамжилмаа	Эрүүл мэндийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
11	Баян-Адарга	Н.Анхбаяр	Мал эмнэлгийн газрын дарга
12	Дадал	Б.Түмэнжаргал	Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
13	Норовлин	Б.Бат-Эрдэнэ	Онцгой байдлын газрын орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн дарга
14	Батноров	Д.Баярхүү	Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга
15	Баян-Овоо	Х.Уртнасан	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дарга
16	Мөрөн	Н.Үнэнбат	Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
17	Хэрлэн	Д.Эрдэнэбаатар	Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын Захирагч
18	Бор-Өндөр	Э.Жавхлантөгс	Цагдаагийн газрын дарга



20 10 200

۹۴۴

پہلے کا نام

پس تمام محرم مر محرم صغیر است. انحصار صوابین مر انحصار صغیر و انحصار صغیر است. در محرم صغیر در ۶۶ هجری قمری
مر ۶۶ هجری قمری. یحیی. سیحی و یحیی یحیی در محرم صغیر در ۶۶ هجری قمری مر ۶۶ هجری قمری. ۶۶ هجری قمری. ۶۶ هجری قمری.
نہیں. یحیی یحیی در محرم صغیر مر ۶۶ هجری قمری و ۶۶ هجری قمری. ۶۶ هجری قمری. ۶۶ هجری قمری. ۶۶ هجری قمری.
۶۶ هجری قمری. ۶۶ هجری قمری. ۶۶ هجری قمری. ۶۶ هجری قمری. ۶۶ هجری قمری. ۶۶ هجری قمری. ۶۶ هجری قمری. ۶۶ هجری قمری.
نہیں. ۶۶ هجری قمری. ۶۶ هجری قمری. ۶۶ هجری قمری. ۶۶ هجری قمری. ۶۶ هجری قمری. ۶۶ هجری قمری. ۶۶ هجری قمری. ۶۶ هجری قمری.

[illegible][illegible][illegible][illegible][illegible]

بسم الله الرحمن الرحيم
الحمد لله رب العالمين